

## УДИРТГАЛ

### **Төслийн шаардлага:**

Монголчууд Евро Азийн төв хэсэгт 3200 гаруй жилийн тэртээгээс өнөөг хүртэл оршин байж, энэ уудам хугацаанд өөрийн гэсэн өвөрмөц соёлыг бүрэлдүүлэн тогтоосон байдаг. Түүхэн урт хугацаанд газар нутгийн хувьд цэвэр усны хагалбар нутаг болох Алтай, Хангайн уулсаар тогтвортой оршин сууж, байнгын тэлэлт, агшилтанд байж, дэлхий дахиныг удаа дараа засаглан, улс хоорондын харилцаанд шинэ, шинэ үеүүдийг нээн өгч, **МОНГОЛЫН ЭНХ АМГАЛАНГ** (Pax Mongolica) **160 гаруй жил дэлхийн дайтад тогтоон** барьж байсан энэ ард түмэнд гүн ухаан, нийгэм, улс төр, эдийн засаг, одон орон судлал, анагаах ухаан, соён гэгээрүүлэх зэрэг дэлхий нийтийн нэгдмэл үнэт зүйлсүүдийг буй болгон, түүнийг хөгжүүлэх үйл явцад онцгой үүрэг гүйцэтгэж ирсэн түүх байна.

Хүмүүн төрөлхтний соёлын санд зөвхөн урлан бүтээх хүрээнд хадны зурмал, сийлмэл зураг, буган чулуун хөшөө, амьтдыг загварчлан дүрслэх, тамга тэмдэг, төрт ёсны тахил шүтээн, хээ угалз, өмсгөл гоёл зүүсгэл зэрэг үнэлж баршгүй соёлыг нийтлэлүүдийг оруулсаар ирлээ. **«Үлэмж ертөнцийн “нэг амьт” зүй тогтолцоонд шүтэн барилдсан байх зарчмууд»**-ыг гол тэнхлэг үзэл санаа болгон дээрх соёлын нийтлэлүүдийг бүтээсэн юм. Монгол соёлыг бүтээх үзэл санааны энэ үндсэн зарчмаа үлэмж ертөнцийн дээд, дунд, доод тивүүдийн харилцан шүтэлцэлт тогтолцооны хүрээнд авч үзсэнээр, мөнхийн хөдөлгөөнтэй нүүдлийн соёлыг асар уудам орон зайн сэтгэмжтэй болгож өглөө. Ийм учир монголчуудыг **соёл, оюуны ухамсартай үндэстэн улс** гэж үзэж болдог.

Дээрх соёлын нийтлэлүүд бүтээгдсэн цаг хугацааны хувьд өөр өөр, ар араасаа залган уламжлагдсан шинжтэй байдаг. Гурван мянга гаруй жилийн тэртээгээс соёлын үзэл санааны нэгэн хэцэн дээр бүрэлдэн тогтож, хувирч өөрчлөгдөлгүй байнга шинэчлэгдсээр ирсэн эдгээр нийтлэлүүдийг ерөнхийлэн **«монголчуудын дүрслэн чимэглэх соёл»** хэмээн нэрийдэж, хэвшмээр байна.

Монголчуудын хувьд дүрслэн чимэглэх соёлын бүтээх арга зүй болсон **арга билгийн ухааны үүднээс «утга илэрхийлэн дүрслэх зарчмууд»**-ыг судлан тогтоосон тов тод томъёололтой байх нь зүйд нийцсэн хэрэг хийгээд өнөө хүртэл соёл судлалын шинжлэх ухааны хүрээнд судлагдахгүй байсаар ирлээ. Үүний тулд **«утга илэрхийлэн дүрслэх зарчмууд» хэмээх нэршлээс**

**эхлэх** болж байна. Монголчуудын биет болон, биет бус соёлын хүрээнд ийм нэршлийг өнөө хүртэл хараахан хэрэглээгүй байна.

Монгол ардын дүрслэн чимэглэх соёлд аливааг урлан бүтээхдээ нүүдэлчдийн ертөнцийг үзэх үзлийн язгуур үндэс болсон **арга билгийн ухаан, үлэмж ертөнцийн юмс үзэгдлийн “нэг амьт” шүтэлцэлт шинж чанар** дээр тулгуурласан үзэл санаагаар ул хийж, утга илэрхийлэн дүрслэх зарчмуудаар дамжуулан гаргаж ирдэг. Энэхүү сэтгэлгээний үйлдлээ (утга илэрхийлэн дүрслэх зарчмууд) заавал **“гурван тивийн”-ийн төлөөлөлт дүрүүдтэй (үлэмж ертөнцийн орон зайтай) шүтэлцүүлэн оюун санаандаа тодорхой нэгэн дүр бүтээж** түүнийгээ нүүдлийн соёлын бичил орон зайд урлан бүтээж буй болгодог. Ингэж үлэмж ертөнцийн орон зайтай өөрсдийн үзэл санаагаа шүтэлцүүлсэнээр нүүдлийн соёлын сэтгэлгээг уудам, орон зайн шинж чанартай бусад соёлын хэлбэрүүдээс тод ялгагдам болгож өгдөг. Ерөөс хүний ямар нэгэн «дүр бүтээх арга нь харилцан холбоо шүтэлцэл бүхий бодит, хийсвэр хоёр талтай бөгөөд аль нэгийг нь хэт баримталбал бүтээл уран сайхны чанараа аль нэг хэмжээгээр алдана гэж үздэг»<sup>1</sup> [Рубинштейн.С. 1945. 325] тул **дүр нь өөрөө бодит байдлаас** (оршин байгаа байгалийн үлэмж орон зайн хэлбэрүүд) **тусган авсан дүрс хэлбэр, тухайн ард түмний ертөнцийг үзэх үзэл** (утга илэрхийлэн дүрслэх зарчим) **хоёрын** (арга билгийн) **шүтэлцлийн үр дүнд үүсдэг** нь дээрх өгүүлэмжүүдээс харагдаж байна.

Иймд **утга илэрхийлэн дүрслэх зарчим** гэдэг нь орчин цагийн урлагийн хүрээнд, ямар нэгэн хувь уран бүтээлчийн уран сайхны сэтгэлгээний түвшинд биш, зөвхөн **үндэстэн улсын дүрслэн чимэглэх соёлын хүрээнд авч үздэг, тухайн ард түмний олон зуун жилээр уламжлуулан авч ирсэн, ардач шинж чанартай, тогтсон урлан бүтээх зарчмуудын нэгдлүүдийг** хэлж байгаа юм.

Олон зуун жилээр уламжлагдан ирсэн түүхэн соёлын бүтээх арга замууд болох утга илэрхийлэн дүрслэх зарчмуудыг судлан, энэ үүднээс соёлын өвүүдээ хэрхэн бүтээн туурвиж ирснийг судлан тогтоож, хэрэглээ үүсгэх нь нийгмийн захиалгат хэрэгцээ болооод байна. Учир нь Манж, Орос хоёр их гүрний шууд нөлөөнд тасралтгүй 300 гаруй жил оршин байсан манай ард түмний нэг том оюун санааны хохирол нь соёлын үнэт зүйлийн алдагдал, соёлын дархлааны уналт байдаг.

Монгол улс гадны нөлөөнөөс ангижирч, соёлын яамтай болж, үндэсний нэгдмэл үнэт зүйлээ тодруулан “Алсын хараа-2050” хөтөлбөр дэвшүүлэн,

<sup>1</sup> Рубинштейн.С. Основы общей психологии. М.1945. 325с [Рубинштейн.С. 1945. 325]

**соёлын соён гэгээрүүлэх их үйлсийг эхлүүлж, соёлын боловсролыг хөгжүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг бүс нутгуудад, улс, дэлхийн хэмжээнд эрчимжүүлэх далай их үйлсийг өрнүүлж** буй энэ цог дор монгол соёлын өвүүдээ уламжлалт хэрэглээ болох **утга илэрхийлэн бүтээх зарчмуудын үүднээс** нь сэргээн хөгжүүлэх хэрэгцээ үүдэн гараад байна. Олон зуун жилээр биднээс хөндийрсэн уламжлалт соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд эндүү ташаа хандах, зөв буруу нэрлэх, ойлгох, хэрэглэх, бүтээх байдал нилээд хавтгайрсан байдалтай байна. Ийм нөхцөл байдал дээр соёлын боловсрол олгох, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд нилээд саад бэрхшээлийг туулах болно.

Ингэхлээр бидэнд нэгдсэн нэг бүтээх зарчмуудыг сэргээн уламжлуулах шаардлага үүсэн гарлаа. Монголчуудын энэ соёлын сэргэлтийн их үйлсэд цаг цагийн аясанд эвссэн шинэчлэл явагдах хэдий ч монголчуудын соёлын биет өвүүдийн дархлаа болсон утга илэрхийлэн бүтээх зарчмуудын үүднээс хандах нь хамгаас чухал зүйл хэмээн үзэж тухайн төслийн үйл ажиллагааг энэ үүднээс судалгаа явуулах зорилт тавин ажилласан болно.

#### **Судлагдсан байдал:**

Тухайн төслийн судалгааны судлагдсан байдлыг үндсэн 3 хэсэгт хуваан хийсэн байгаа. Үүнээс эхний ээлжинд **соёлын биет өвийн бүтээх зарчмуудын нэг тал болох арга билгийн гүн ухааны талаарх** монгол судлаачдын үзэл баримтлалыг тоймлон судлах байлаа. Чойжи-Одсэрийн зохиосон “Зүрхний толт”, Молом Рабжамба Данзандагвын найруулсан “Зүрхний толтын тайлбар”, Шаравжамц буюу Билгийн Далайн зохиосон “Монголын үгсийн хүртээл зүрхний толт оршив”, “Алтан товч”, Галдан туслагч “Эрдэнийн эрхи”, Саган цэцэн “Эрдэнийн товч”, Рашпунцаг “Болор эрхи”, Раднаабатар “Равжамба зая бандидын тууж Сарны гэрэл хэмээх оршив” болон хууль цаазын дурсгалуудад тод томруун тусган харуулсан байхаас гадна үе үеийн судлаачид улам чамбайруулан бүтээл туурвилаа хийсээр иржээ. Чойжи-Одсэрийн зохиосон “Зүрхний толт”-ийн жинхэнэ эх бичиг хадгалагдан үлдээгүй боловч түүний үндсэн санаа нь XVIII зууны үеийн Молом Рабжамба Данзандагвын найруулсан “Зүрхний толтын тайлбар”, Шаравжамц буюу Билгийн Далайн зохиосон “Монголын үгсийн хүртээл зүрхний толт оршив” гэсэн хоёр зохиолоор бидний үед уламжлагдан иржээ. Хожуу үеэр арга билгийн гүн ухааныг судалсан судлаачдаар Ноён хутагт Дулдуйтын Равжаа (1803-1856), Гүнгийн Зуугийн

гэгээн Ишданзанваанжил, В.Инжаннаш (1837-1891), Ч.Дэмчигдорж (1863-1932) зэрэг түүхэн хүмүүсийг дурдаж болно.

Олноо Чимидийн Дандаа хэмээн алдаршсан Дэмчигдорж нь «Эрдэнэт толь хэмээх шастир оршвой» алдарт бүтээлдээ: «Жич наран саран хийгээд од гариг ба эд эрхтэн хийгээд таван махбодь, найман хүлэл хийгээд есөн мэнгэ ба өдөр шөнийн ёсон хийгээд чөтгөр сахиулсны хувилах улирах ба уул нуур хийгээд загас мэлхий ба хорхой шоргоолжноос аливаа өвс модонд хүртэл энэ арга билгийн ёсон үгүй нь үгүй. Энэ нь цөм өөрөө болсон, илүү дутуугүй, хослон барилдсан ёсон мөн тул хэн бээр засах эвдэх хийгээд нэмж бууруулж үл чадна. Арга, билгийн ёсон, түүний үндэс нэгэн бөгөөд аргын ёсон хөдлөн буюу. Билгийн ёсон нам буюу. Арга үүрд хөдлөж үл болно. Билиг үүрд нам байж үл болно. Арга билгийг түшиж нам болно. Билиг аргыг дагаж хөдөлнө» гэсэн хамаг гол үзлээ бичиж тайлбарласан байдаг.

Түүнчлэн монгол гүн ухаан, ертөнцийг үзэх үзэл хэрхэн бүрэлдэн тогтсон талаар Ч.Жүгдэр “Монголд феодализм тогтох үеийн нийгэм улс-төр, гүн ухааны сэтгэлгээ” (1987), “ХҮ-ХҮIII зууны монголын нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн тойм” (1984), “XIX-XX зууны зааг дахь монголын нийгэм-улс төр, философи сэтгэлгээний хөгжилт” (1972), “Монголын философийн түүхийг судлах арга зүйн зарим асуудал” (1990), Н.Хавх. “Социологи, Монголын нийгмийн гүн ухааны зарим чиглэлүүд” (2005), “Монголчуудын нүүдлийн соёл иргэншлийн гүн ухаан” (2005), “Буддын сурган, сэтгэл судлал, хүмүүжлийн гүн ухаан” (2006) цуврал бүтээлүүдээ туурвисан байдаг. Доктор Н.Хавх нь Ч.Дэмчигдоржийн арга билгийн онолын дүгнэлтийг задлан доорх тайлбарыг хийсэн билээ.

«Арга, билгийн шүтэлцээ нь бүх юмсын оршин тогтнох үндэс болох тухай

Арга, билиг хоёр эсрэг тэсрэг тал болох тухай

Тухайн тогтолцоонд арга, билгийн гүйцэтгэх үүрэг эсрэг тэсрэг болох нь

Аргын шинж билигт шингэх ёс

Билгийн шинж аргад шингэх ёс

Хоёр туйл буюу туйлшрал

Аливаа юмсын үүсэл хөгжлийн шалтгаан өөрт нь байх

Арга, билиг хоёр нь объектив зүй тогтолтой болох эдгээр болно» гээд тэдгээрийг нэг бүрчлэн тайлбарласан байдаг. Эдгээр үзэл санааг ардын дүрслэн чимэглэх соёлын хүрээнд хэрхэн уялдан зохицож буй талаас нь авч үзлээ.



Өнөө цагт үзэж буйгаар арга билгийн ухааны үүднээс аман зохиолын бүтээлүүдийг хэрхэн бүтээн туурвиж байсан талаар Ж.Долгорсүрэн “Аман соёлын арга билгийн шүтэлцээ” (2000), Ш.Лувсанвандан “Хэл шинжлэлийн асуудлууд” (2000), И.Бүрэн-Өлзий “Зүйр цэцэн үгийн ертөнцийг үзэхүйн утга холбогдол” (2009) зэрэг бүтээлүүд туурвисан нь уламжлалт соёлын далд утга санааг тайлан гаргах аргагүйн загвар болсон бүтээлүүд юм. Ж.Долгорсүрэн «Нүүдэлчин монголчуудын соёл бол байгалиас шууд авч хүчижсэн байгалийн хүмүүний үйл бүтээл, түүний үр дүнгийн тогтолцоо мөн. Ингэж соёлыг бүтээгч хүмүүнийг байгалийн уг эхтэй амьтан буюу “амьд байгаль” гэж үзэх нь далд ухамсрын дотоод түрэлтийн үр дүнд хүмүүний төрөлх боломжинд тулгуурлан бүтээгдэх зөнлиг шинж давамгайлсан соёлын үнэт зүйлсийг ямар нэгэн хэмжээгээр байгалийн үзэгдэл мөн гэж үзэх үндэстэй байна.»<sup>2</sup> хэмээсэн монгол соёлын гол амин чанарыг дэлгэж үзүүлсэн үнэлгээ дүгнэлтийг хийсэн байдаг.

**Дараагийн дугаарт түүх, архиологийн шинжлэх ухааны хүрээн дахь судлаачид Төв Ази түүний дотороос Монгол нутагт хамаарах нутаг дэвсгэрийг хамарсан соёлын үзэгдлүүд, тэдгээрийн үзэл санаа, өнө хойшид хэрхэн уламжлагдан үлдсэн талаар, тэдгээрт шингэсэн үе үеийн ертөнцийг үзэх үзлийн талаар гадаад, дотоодын олон арван судлаачид өөр өөрийн бүтээлүүдийг туурвисан байдаг. Эдгээрээс Д.Цэвээндорж “Монголын хүй нэгдлийн урлагийн дурсгал” (1983), “Монголын палеолитын урлагийн шинэ дурсгал” (1980), “Монгол нутгаас олдсон зарим буган чулуун хөшөө” (1979), “Буган чулуун дээрх сар, өдөр тоолох зүйлс” (1975), Х.Пэрлээ “Монгол түмний гарлыг тамгаар хайх нь” (1976), Ч.Далай “Монгол бөө мөргөлийн товч түүх” (1959), Г.Сүхбаатар “Монголчуудын эртний өвөг “ (1980), О.Пүрэв “Монгол бөөгийн шашин” (1999), Ц.Батсайхан “Монгол нутгаас олдсон эртний нүүдэлчдийн урлагийн дурсгал” (2004), Л.Дашням, А.Очир, Д.Цэвээндорж, Н.Уртнасан “Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал” (1999), Ч.Болдбаатар, С.Дэлгэр “Хүннүгийн түүх, соёл” (2011), Гомбрих Э.Х. “Урлагийн түүх” (1995), Д.Цэвээндорж “История древнего искусства Монголии” (1999), Дэвлет М.А. “Мозага-Комужап паметник наскального искусства в зоне затопления Саянской ГЭС” (2009), В.Д.Кубарев “Хронология и интерпретация сюжетов /Петроглифов Цагаан-Салаа и Бага-Ойгура” (2005), Екатерина Дэвлет, Чжан Со Хо. “Каменная летопись Алтая” (2014) зэрэг бүтээлүүдээр монгол нутаг, Төв Азийн хүрээний түүхэн дурсгалуудын судалгааны хүрээг авч үзэж болно. А.П.Окладников эрдэм**

<sup>2</sup> Долгорсүрэн Ж. Аман соёлын арга билгийн шүтэлцээ /Хян. С.Мэндээ.-УБ.: Урлах эрдэм ХГ, 2000.-66х.

шинжилгээний олон арван илтгэл, өгүүлэл нийтлүүлэн “Монгольский археологический сборник” (1963), “Утро искусство”, “Центрально Азиатский очаг первобытного искусства” (1967) бүтээлүүдийг туурвин Э.А.Новгородова “Мир петроглифов Монголии” (1984), Новгородова Э. А. Древняя Монголия. (Семантика и новая хронология памятников) Доклад на V Международный конгресс Монголоведов (1987), түүний “Древняя Монголия” (1989), Николай Рерик “Зажигайте сердце” (1975) зэрэг бүтээлүүдээ тус тус туурвисан байдаг. Түүнчлэн монгол соёлыг тал бүрээс нь өөр, өөрсдийн чиглэлүүдээр судалсан судлаачдын бүтээлүүдээс Г.Е.Грумм-Гржимайло “Западная Монголия и Урианхайский край” (1926), Н.В.Кочешков “Мастера Монгольской культуры” (1971), Н.В.Кочешков “Народное искусство Монголов” (1973), Н.В.Кочешков “Декоративное искусство Монголо язычных народов XIX-середины XX века” (1979), В.А.Кореняко “Монгольская народная скульптура” (1990), С.В.Иванов “Киргизский орнамент как этногенетический источник. ТКАЭЭ” (1959) зэргийг дурдаж болно.

Гуравдугаарт **ойрад монголчуудын хүрээнд дүрслэн чимэглэх соёлын бүтээх зармуудын талаарх судлагдсан байдлын судалгаа** хийлээ. Ойрад монголчуудын дүрслэн чимэглэх соёлын уламжлалт бүтээх зарчмуудын үүднээс тандан судалсан бүтээл нэн ховор байна. 2019 оны байдлаар ойрадчуудын түүх, өв соёлтой холбогдуулан судалгаа хийсэн нэг сэдэвт бүтээл 20 гаруй, сурвалж зохиол ном судрууд монгол хэлээр 3, гадаад хэлээр 1, докторын зэрэг горилсон бүтээл 5, ном товхимол 22, баримт бичгийн эмхэтгэл 7, эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл 6, эрдэм шинжилгээний өгүүлэл 128, эрдэм шинжилгээний илтгэл 114, сонины өгүүлэл 50, тэмдэглэл дурсамж, шүүмж 2, олон улсын хамтарсан төсөл 11, суурь судалгааны төсөл 3 тус тус байна.

Эдгээрээс ойрадчуудын дүрслэн чимэглэх соёлтой холбоотой Амгалан М. Баруун Монголчуудын эдийн соёлын дурсгалт зүйлс. УБ., 1999 бүтээл нь ойрадчуудын 10 угсаатны бүлгийн тамга тэмдэг, хувцас, өмсгөл зүүсгэл, гэр орон сууц, ахуйн эдлэл хэрэглэл, алт мөнгөний дархчуулын багаж хэрэглэл, урласан бүтээл зэргийг 40 шахам жил судалж, нилээд нийтлэг байдлаар нарийвчлан зурж үлдээсэн 9 бүлэг, 305 хуудас бүтээл юм. Энэхүү бүтээл нь биет соёлын өвийн хэрэглээ хомсдолд орсон өнөө үед нэн чухал бааз суурь болж байна. Баасанхүү А. Монгол Алтайн бүс нутгийн ард түмний эдийн соёл. Хянан тохиолдуулсан: доктор (Sc.D), профессор Х. Цохүү УБ., 2006, Баасанхүү

А., Батмөнх Б. Монголын Ойрадуудын соёл (XIX-XX зууны зааг үе) Редактор: Доктор, профессор Л. Дашням УБ., 2010 зэрэг соёлын биет өвийн талаар нэг сэдэвт бүтээлүүд хийгдсэн байна.

Түүнчлэн Батбаяр Б. Захчины түүх соёл судлал. Худам үсгээс кирилл үсэгт буулгасан Г.Ядамжав //BIBLIOTHECA OIRATICA-XXXVI УБ., 2014 Катууб. Монгол туульсын бэлэгдэл. Хянан тохиолдуулсан доктор Х.Сампилдэндэв УБ., 1996, Катууб. Монгол туульсын судалгаа (Бэлгэдлийн судалгаа) II боть Эрхлэн хэвлүүлсэн На.Сүхбаатар //BIBLIOTHECA OIRATICA-XXXII УБ., 2013, Монгол улсын угсаатны зүй. Ойрадын угсаатны зүй. XIX-XX зууны зааг үе 2 боть Эрхэлсэн С. Бадамхатан УБ., 1996, Монгол улсын угсаатны зүй. Ойрадын угсаатны зүй. (XIX-XX зууны зааг үе) II боть. Нэмэн засварласан хоёр дахь хэвлэл. Эрхэлсэн С. Бадамхатан, Г. Цэрэнханд УБ., 2012, Мэнэс Г. Захчин түүхэн угаатны зүй. Эмхэтгэн хэвлүүлсэн У.Эрдэнэбат., Ч.Амартүвшин УБ., 2018, Намжилт Т. Ойрад Монголын шүтлэг бишрэлийн зан үйлийн соёл. Кирилл үсэгт хөрвүүлж, хэвлэлд бэлтгэсэн Ц.Нямсамбуу //BIBLIOTHECA OIRATICA-LIVI УБ., 2017, Цолоо Ж. Батжав Б. Арван гурван сангийн орон. Захчины угсаатны судлал, хэл шинжлэлийн тэмдэглэл. УБ., 2004 Эрэнжэй Ж., Намжил Т. Ойрадын зан заншил. ШАХХ. Өрөмч, 1995 (Тод монгол бичгээр), Эрдниев У.Э. Калмыки. Историко-этнографические очерки. Элиста., 1985. 282 с, Эрдниев У.Э. Историческая судьба ойратов. Элиста., 1993. 150 с зэрэг ойрадчуудын угсаатны бүлгүүдийн зан үйл, ертөнцийг үзэх үзэл, аман бэлгийн судалгаанууд хийсэн бүтээлүүд байна.

Алтанзаяа Л. Ойрад Монголчуудын соёл (XVII-XVIII зууны дунд үе). Түүхийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон зохиол УБ., 2000, Болормаа О. Ижил мөрний зүг нүүсэн Ойрадуудын нүүдэл (XVII-XVIII зуун) Түүхийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон зохиол УБ., 2007, 3. Ганбат Н. Торгуудын түүх угсаатны зүйн асуудалд Түүхийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон зохиол УБ., 2013, Мөнхбаатар Д. Хөхнуурын Хошуудын түүхэн замнал, угсаа гарлын хамаарлын асуудалд. Түүхийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон зохиол УБ., 1997, Чойдандар Ц. Алашаа хошууд түмэн: зан үйлийн уламжлал. Түүхийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон зохиол УБ., 1992 нарын судалгааны бүтээлүүдээс XVII-XVIII зууны дунд үеийн ойрадчуудын соёлын хэв шинж, ойрадчуудын ижил мөрөн тийш нүүсэн үеийн хэв шинж, хөх нуурын хошуудын гарал үүслийн талаарх нилээд товтой судалгааны мэдээлэл агуулсан бүтээлүүд байдаг.

Баасан Н. Ойрад монголчуудын хувцас хунарын тухай //Шинжааны өдрийн сонин. 1997.07.17, Баасан Н. Ойрад монголын хувцас хунар ба засал чимэглэл //Шинжааны өдрийн сонин. 1997.04.02, Баасан Н. Ойрад монголчуудын эрээ хамгалтын тухай //Шинжааны өдрийн сонин. 1998.02.23 зэрэг сонины өгүүллүүд, Гэрэл Х. Ойрад Монголчуудын найр хуримын ёсон дахь бэлгэдлийн сэтгэлгээ асуудал // Mongolica. Vol 11 (32) Volume 3. An International Annual of Mongol Studies. A Special issue containing the papers of Sixth International Congress of Mongolists (12-16 August 1997. Ulaanbaatar) УБ., 2001, тал 57-62, Зугдаа Ж. Ховд аймгийн Булган сумын Хошуудын соёл урлаг, зан заншлын зарим онцлог //Хошуудын түүх, соёл (Эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэл) Эмхэтгэж, эрхлэн хэвлүүлсэн Ү.Мөнхдагва, На.Сүхбаатар. BIBLIOTHECA OIRATICA- LXXVIII УБ., 2018, тал 79-81, Давааням Ж. Дөрвөд түмний малын им тамганы соёл //Ойрад Монголын түүх, соёлын асуудлууд. Оюутны ЭШБ №1. Эмхэтгэн хэвлүүлсэн Н.Наранжаргал, Б.Адъяа, У.Анхдалайбаяр, Д.Баярсайхан, И.Чулуунболд УБ., 2011, тал 50-55, Буян-Орших Б. Ойрад монголчуудын “дэгрээ” тамганы үүсэл хувирал, уламжлал, тархалтын асуудал //Ойрад Монголын түүх, соёлын асуудлууд. Оюутны ЭШБ №4. Эмхэтгэн хэвлүүлсэн Н.Наранжаргал, Б.Нанжид, Г.Мандахбаяр, Ц.Рейс УБ., 2015, тал 77-82 зэрэг судалгааны өгүүллүүд ойрадчуудын соёлын талаарх үзэл санаануудыг илэрхийлсэн байдаг.

**Судалгааны зорилго:** Ойрад монголчуудын дүрслэн чимэглэх соёлыг арга билгийн ухаантай шүтэн барилдсан утга илэрхийлэн бүтээх уламжлалт зарчмуудын үүднээс судалсан нэг сэдэвт бүтээлтэй болох.

**Эдийн засаг, нийгмийн болон шинжлэх ухааны ач холбогдол:**

Тухайн төслийн судалгааны үр дүнг нийгмийн харилцааны хүрээнд ач холбогдол бүхий ашиглах хэд хэдэн боломж байна.

1. Ойрад монголчуудын жишээн дээр нийт монголчуудын дүрслэн чимэглэх соёлын бүтээх зарчмуудын уламжлалт хэрэглээг анхлан сэргээн судалсан нэг сэдэвт бүтээлтэй боллоо.
2. Соёлын биет өвийг бүтээх нэгдсэн зарчмын судалгаа хийгдснээр бүс нутгийн, улс, дэлхийн чанартай соёлын бүтээлч үйлдвэрлэлийг уламжлал дээр суурьлан хөгжүүлэх боломжтой боллоо.
3. Соёлын дархлааг өөртөө агуулан байдаг нэгдсэн энэ бүтээх зарчмуудаар дамжуулан соёлын боловсролыг хүүхэд залуучуудын шат шатны сургалтанд олгох боломж бүрдэж байна.

4. Монгол соёлын биет өвүүдийг хадгалсаар байгаа улс, аймаг, сумын музейнүүд соёлын өвийн тайлбарыг утга илэрхийлэн бүтээх зарчмуудын үүднээс гадаад, дотоодын аялагчид, ард олонд хийх боломж бүрдлээ.

### **Судалгааны арга зүй:**

Тухайн төслийн судалгааны ажлын судлах зүйл (объект) нь монголчууд үлэмж ертөнцийг өөрсдийн нийгэмших үйл явцдаа зориулан тэмдэглэгээнд хэрхэн шилжүүлсэн тохиолдлуудыг (монгол ардын дүрслэн чимэглэх соёлын хүрээнд) тайлан унших үйл явц гэж үзэж болно. Хад, агуйн зурмал, сийлмэл зургууд, буган чулуун хөшөө, хүрэл цутгуурын, түүнчлэн амьтны загварчлан дүрслэх бүтээлүүд, хүннүгийн туурган хивс зэрэг монгол соёлын тулгын чулуу болсон бүтээлүүдэд байгалиас хүнд өгөгдсөн утга санаа хэрхэн тэмдэглэгдэж үлдснийг тайлан уншихдаа тэмдэг зүй-бүтэц зүйн (семиотика) аргыг, түүнчлэн бэлгэдэл зүйн аргыг гол болгон ажиллахыг хичээнгүйлэв.

Монголчуудын дүрслэн чимэглэх соёлын бүтээлүүд болох тамга тэмдэг, хээ угалз, хувцас, өмсгөл зүүсгэлийн хээ чимэг зэргийн утга санаа, үндсэн дүр, дүрс, өнгө, зүг чигтт хандсан сэтгэлгээ, давтамжуудыг судлахдаа тайлан тайлбарлах арга (херменевтик), дохио тэмдгийн оршихуйн үндэс, эх сурвалжийг эрж хайж ойлгох зэрэг аргаар ухаж тайлах, үндэслэл гаргах зэргээр судалгаа хийсэн болно.

Дүрслэн чимэглэх соёлын дүр, дүрслэлийн өвөрмөц онцлог, түүнийг бүтээн буй болгосон арга ухаан нь арга билгийн ёсон өөрөө мөн бөгөөд тэдгээрийг тайлан унших үйл явцад өөрөө эргээд аргагүй нь болдог. Эдгээр гол үйл явцаас урган гарсан утга санааг боловсруулан утга илэрхийлэн дүрслэх зарчмуудыг нь системчлэхийн тулд жишин судлах индуктив, дедуктив оюун дүгнэлтийн үүднээс биет соёлын үзэгдлийг задлан шинжилж (анализ), нэгтгэн дүгнэх (синтез) аргуудыг хэрэглэв.

Түүнчлэн Увс, Ховд, Баян-Өлгий аймгийн нутагт оршин суугаа угсаатны бүлгүүдэд хээрийн судалгаа явуулж, 100 гаруй настнууд, өв тээгчдээс аман мэдээ авч, Ховд, Увс, Баян-Өлгий аймгуудын музей, тэдгээр аймгуудын зарим сумуудын, Үндэсний түүхийн музей, Улаан баатар музей, Чингис хаан музейн үзмэрүүдэд судалгаа хийж, тэдгээрт хадгалагдаж буй соёлын биет өвүүдэд бүтээх зарчмын харьцуулсан судалгаануудыг хийлээ.

## **Судалгааны үр дүн:**

### 1. Судалгааны нэг сэдэвт бүтээл

Д.Гантулга. Ойрад монголчуудын дүрслэн чимэглэх соёл. Хянан тохиолдуулсан С.Дулам. УБ., 2022 (22,6 х.х) ISBN 9978-9919-0-000-4

2. Хамтарсан төслийн хүрээнд гадаадын мэргэжлийн сэтгүүлүүдэд 6 өгүүлэл, дотоодын сэтгүүлд 1 өгүүлэл тус тус хэвлүүлж, олон улсын эрдэм шинжилгээний хуралд 3 илтгэл хэлэлцүүлсэн байна.

3. “Дөрвөд далай хааны цэцэгээс тодорсон Цэц вангийн хошууны аав ноён Яргай ястай, Ховд аймгийн Дөргөн сумын иргэн Лэгзэнгийн Мигжингийн бүтээсэн соёлын биет өвүүд” сэдэвт Дөргөн сумын Амгаланг үүсгэгч Майдарын гэгээний хийд, Дөргөн сумын соёлын төвд бүтээж өгсөн Дөрвөд угсаатны бүрэн тавилагатай гэр, дөрвөд угсаатны соёлын талаарх аман мэдээ оруулсан 2цаг 30 минутын видео, баримтат бүтээл хийсэн байна.

4. Монголын үндэсний радиогийн “Нийгэм соёлын хэлтэс”-тэй хамтран Урианхай, Захчин, Мянгад угсаатнуудын хувцасны соёлоор тус тус 20 минутын цуврал нэвтрүүлэг бэлтгэсэн байна.

## **ДҮГНЭЛТ:**

Хүрэл зэвсгийн хожуу, төмөр зэвсгийн түрүү үеэс үлэмж ертөнцийг дээд, дунд, доод гурван тивд хуваан үзэх үзэл санаа боловсорч хад, агуйн зургууд, амьтдыг загварарчлан дүрслэх соёл, овгийн тахил шүтээн, тамга тэмдэг, буган чулуун хөшөө, хүннүгийн түүхэн дурсгалуудаар дамжин монголын нэгдсэн улс, Богд хаант улсын үе, улмаар өнөө бидний дүрслэн чимэглэх соёлд утга алдагдалгүй уламжлуулан шингээж, хөгжүүлэн ирсэн байна. Өгүүлсэн цаг хугацаанд үлэмж ертөнцийг танин мэдэж түүнийг дээд, дунд, доод гурван тивд хуваан, тэдгээрүүд дахин дотооддоо хуваагдан шүтэлцэж байхаар загварчлаад энэ талаарх үзэл санаагаа түүхэн бүтээлүүдэд мөнхлөн үлдээхдээ, дээд (сав ертөнц), доод (шим ертөнц) тивүүд голлон шүтэлцэх агаад, энэ үйл явцын үр дүнгээс дунд тивийн үйл амьдрал харилцан хамааралтай гэж үзэх гол үзэл санааг боловсруулан гаргаж ирсэн байна. Цаг хугацаа өнгөрөх тусам аливааг хоёр хүчин зүйлээс хамааруулан үзэх энэ үзэл санаа өөрийг нь хэрхэн нэрлэхээс үл шалтгаалан улам боловсронгуй болж хөгжсөөр өнөө бидний үед утга санаагаа алдалгүй хүрч ирлээ.

Ингээд **үлэмж ертөнц өөрөө илүү дутуугүй хослон барилдсан хэн нэгэн өөрчлөх боломжгүй зөвхөн хүлээн зөвшөөрч, эвсэн оршихоос өөр аргагүй «нэгэн амьт» орон зай юм бол хүмүүн бидний бүтээх соёл түүн**

**дотроос дүрслэн чимэглэх соёлын бүтээлүүд нь энэ тогтолцоонд харилцан шүтэлцэж, нэгдэн ууссан танивар дохио (кодоор) тэмдгээр дамжих ёстой болоод байна.**

Монголчууд үлэмж ертөнцийн бүтэц, зүй тогтлыг загварчлан, бичил ертөнцийн тогтолцоог үүсгэхдээ харьцаат хэмжээ-орон зай, өнгө-зүг чиг, хэлбэр дүрс-хэмнэл хөдөлгөөн гэсэн бүтэцтэйгээр авч үзсэн байдаг. Энэ хосолсон бүтцийг авч үзвэл харьцаат хэмжээ-үлэмж ертөнц, өнгө-үлэмж ертөнц, хэлбэр дүрс-үлэмж ертөнц гэсэн тогтолцоо байна. Цааш нягтлан үзвэл тогтолцоо бүртэй холбогдсон үлэмж ертөнцийн үүрэг нь өнөөгийн шинжлэх ухааны үүргийг гүйцэтгэх мөртлөө хэт их материаллаг хэрэгцээг хааж, байгальд ээлтэй байх нөхцлийг бүрдүүлж өгдөг байна.

Бичил ертөнцийн тогтолцоог үлэмж ертөнцтэй (дээд, дунд, доод тивүүдтэй) нэгэнт холбон үзсэн тул үндсэндээ **үлэмж ертөнцийн бүтэц, тогтолцоо, хуулийн дагуу сэтгэн бодож, бүтээн туурвих зарчмыг баримталахаас өөр аргагүй нөхцөлтэй** байна. Ингэхлээр монгол үндэстний соёлыг бүрдүүлсэн гол зарчим нь бичил ертөнцийг үүсгэн бий болгохдоо үлэмж ертөнцийн загвар, тогтцоос шууд утгаар нь суралцсан үйл явц гэж үзэж болно.

Үлэмж ертөнцийн бүтэц, тогтолцоог үзэх үзэл, бичил ертөнцийн тогтолцооны өвөрмөц байдал, түүхэн урт хугацаанд үндэстэн бүрэлдэн тогтох үйл явцын хүрээнд дагаж явагдсан ардын дүрслэн чимэглэх соёлд аливааг хоёр хүчин зүйлд тулгуурлан үзэх ухааны үүднээс хэрхэн хандаж байсан уламжлал дээр тулгуурлан **арга билгийн чанарт утга илэрхийллүүдийн бүтээх аргын зарчмуудыг үүсгэн төлөвшүүлсэн** байна.

Монголчууд бичил ертөнцийг буй болгохдоо оршин байгаа орон зайг танин мэдсний үр дүнд түүнд орших **харьцаат хэмжээнд шүтэн барилдах арга зүйг зохиосон нь арга билгийн шүтэлцэлт чанарт утга илэрхийллээр бүтээх зарчмын үндэс суур** болдог. Ерөөс хүссэн хүсээгүй харьцаат өгөгдөлд (хүн, таван хошуу мал, гэршүүлсэн амьтад г.м) таацсан хэмжээт шүтэлцлийн замаар бичил ертөнцийг бий болгох зам тэдний өмнө байсан гэж үзэж болно. Үүнийгээ үлэмж ертөнцийн орон зайг танин мэдсэн түүхэн хугацааны бүтээл болох ертөнцийг үзэх үзлийн нэг салбар аливааг хувь тэнцүү үзэх үзэлтэйгээ шүтэлцүүлэн утга илэрхийллийг бүтээсэн байна.

Үлэмж ертөнцийн бүтэц дээр тулгуурлан шим ертөнцөд хамаарах бүхнийг билигт хамааруулан үзээд, тэр бүхнийг шүтэлцэлд орж өрнөн хөгжиж байгаа байдлуудыг дүрслэн чимэглэх соёлын зүйл бүр дээр тухайлан авч үзэхэд

**билиг чанарт утга илэрхийлэл нь дотроо билгийн арга чанарт, билгийн билиг чанарт зарчмуудаар утга илэрхийлж болох тогтолцоо байгаа нь бүрэн нотлогдоод байна.**

Үлэмж ертөнцийн бүтэц дээр тулгуурлан сав ертөнцөд хамаарах бүхнийг аргад хамааруулан үзээд, тэр бүхнийг шүтэлцэлд орж өрнөн хөгжиж байгаа байдлуудыг дүрслэн чимэглэх урлагийн зүйл бүр дээр тухайлан авч үзэхэд **арга чанарт утга илэрхийлэл нь аргын арга чанарт, аргын билиг чанарт зарчмуудаар утга илэрхийлж болох тогтолцоотой байгаа нь нэгэн адил нотлогддог** гэсэн үг юм.

Монголчуудын дүрслэн чимэглэх соёлын төрөл зүйлийн агуулга, өгүүлэмжээс арга билгийн харилцан шүтэлцээт тогтолцоог тодорхой харж болно. Учир нь үлэмж ертөнцийн дээд (сав ертөнц), доод (шим ертөнц) тивүүд болох үндсэн хоёр гол хүчин зүйлээс дунд тивийн амьдрал түүнд хамаарах бүхэн шууд утгаараа хамааралтай хийгээд хүний гар, оюун ухаанаар бүтэх эд зүйлүүд хүртэл энэ зарчмаар бүтээгдэж байх ёстой гэсэн үзэл санааг гол тэнхлэгээ болгосон соёлын хувьсал хуучин чулууны үеэс өнөөг хүртэл явсаар ирсэн байна. Энэ нь ерөнхийдөө үлэмж ертөнцийн зүй тогтлын дагуу сэтгэ, бүтээ, хэрэгжүүл гэсэн зарчим юм.

**Ойрад монголчуудын дүрслэн чимэглэх соёлд дээр өгүүлсэн утга илэрхийлэн бүтээх зарчмуудаар дамжин бүтээгдээгүй нэг ч соёлын өв байхгүй юм.**

**Утга илэрхийлэн бүтээх зарчмууд нь олон зуун жилийн явцад бүрэлдэн тогтдог хийгээд ингэж бүрэлдэн тогтсон нэгдсэн нэг бүтээх зарчимууд соёлын дархлааг өөртөө агуулж байдаг хийгээд соёлын үнэт зүйлүүдийг дархалж өгдөг юм байна.**

Бид 300 гаруй жил гадны хүчтэй үзэл суртлын нөлөөнд оршин байсан дүрслэн чимэглэх соёлын бүтээх зарчмуудыг сэргээн босгож чадваас жинхэнэ утгаарай соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжтой болох юм байна.

#### **НОМ ЗҮЙ:**

1. Амгалан М, Баруун монголчуудын эдийн соёлын дурсгалт зүйлс. УБ, 2004
2. Батболд Н, Монголын хадны зураг Монголын археологийн өв. Цуврал зурагт цомог IV боть. УБ, 2016
3. Баттулга Ц, Монголын руни бичгийн бага дурсгалууд. Тэргүүн дэвтэр. Corpus scriptorum, Tomus I, 2005



4. Батчулуун Л, Монголчуудын түүх соёлын атлас УБ. 2006.
5. Батчулуун Л, Монгол дарханы урлаг. УБ. 2009
6. Батчулуун Л, Эсгийн урлаг, тэмдгийн тогтолцоо УБ. 2003
7. Баярсайхан И, Монгол хэлний тайлбар толь, Улаанбаатар, 1996
8. Бум-Эрдэнэ (БЭ). Б.Катуу хэвлэлд бэлтгэв. Ардын боловсролын Яамны хэвлэл, Улаанбаатар, 1985
9. Бухын Сандагийн Мянгад судлалын бүтээл туурвил. Улаанбаатар, 2015
10. Гантулга Д, “Художественная выразительность в орнаменте войлочных ковров”. Искусство Еврази. Международный научный журнал. №3(6)\*.2017 стр13-19
11. Гантулга Д, Монголчууд үлэмж ертөнцийн орон зайд. УБ. 2017
12. Гантулга Д, “Художественная выразительность оленных камней”. Искусство Еврази. Международный научный журнал. №2(5), 2017, стр14-19
13. Гантулга Д, Монгол ардын дүрслэн чимэглэх соёлын арга билгийн утга илэрхийлэл. Соёл судлалын ухааны докторын зэрэг хамгаалсан бүтээл. УБ, 2017
14. Гедеева Д.Б., Гантулга Д, “Буддийская символика в системе калмыцких тамг” // Монголоведение. 2020, № 1, С. 141–152. DOI: 10.22162/2500-1523-2020-1-141-152. С. 141-152.
15. Гантулга Д, “Монгол ардын дүрслэн чимэглэх урлагийн арга чанарт утга илэрхийлэн дүрслэх зарчим” Солонгос улсын Монгол судлалын холбооны "Монгол орон судлал" сэтгүүлд. Сөүл. 2017.07, ISSN 2508-6510, 35-42х
16. Гантулга Д, “Философское учение арга-билиг и категория числа в культуре монголов”. Вестник АГТУ им И. И. Ползунова Барнаул № 1-2 2010. стр 103. Лицензия на издательскую деятельность ЛР № 020822 от 21. 09. 98г.
17. Гантулга Д, “Цветовая, числовая и образная символика монголов в контексте учение арга билиг”. Мир науки, культуры, образования. Международный научный журнал. ISBN 1991-5497. Август. 2011. №4. стр 375.
18. Гантулга Д, Ойрад эмэгтэйчүүдийн гоёл чимэглэл”, МУИС-ийн Ховд дахь салбар сургууль, НУТ –ын ЭШБ 12дугаар боть. Ховд 2003он.
19. Гантулга Д, Буган хөшөөний зохиомж арга, билгийн шүтэлцээт дүрийн уран сайхны сэтгэлгээ болох нь. ХИС-ийн ГХСС-ийн ЭШБ. 2014. №7- УБ.133-138-р тал.
20. Гантулга Д, Эвэр хээний үүсэл, утга илэрхийлэл. Солонгос улсын Монгол судлалын холбооны "Монгол орон судлал" сэтгүүлд. Сөүл. 2017.07, ISSN 2508-6510, 35-42х

21. Гантулга Д, “Орнамент в системе декоративно-прикладного искусства монгольских народов” Вестник Калмыцкого университета. 2020. № 2 (46), стр 6-11
22. Гантулга Д, “Улзий-символический орнамент благополучие и центр макромира монгольских кочевников”. «Этнодиологи». Научно-информационных альманах. №3(61)2020.-236с.
23. Гантулга Д, Цвет и пространств традиционной культуре ойратов монголии и кальмыков в россии”. Журнал «История и философия культуры и искусства». Том 4 №2 \2021\ ISSN2618-7140, стр 86-95
24. Дамбажав И, Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан монгол үгийн дээж., II боть, Ө-ЯШИН, Улаанбаатар, 2010
25. Дарамбазар Х, Ариун ёс. “Арвис”, Улаанбаатар, 1992
26. Дулам С, Монгол бэлгэдэл зүй. II өнгийн бэлгэдэл зүй зүг чигийн бэлгэдэл зүй УБ. 2011
27. Дулам С, Чингис хааны төрийн бэлгэдэл. УБ. 2014.
28. Дулам С, Монгол бэлгэдэл зүй. III дүрсийн бэлгэдэл зүй дохио зангааны бэлгэдэл зүй УБ. 2011.
29. Дулам С, Домог зүй, бөө мөргөлийн судалгаа. УБ. 2018.
30. Дулам С, Монгол бэлгэдэл зүй I боть. Тооны бэлэгдэл зүй. УБ. 2011
31. Дулам С, Бэлгэдэл зүйн судалгаа., Улаанбаатар, 2018
32. Дулам С, Монгол бэлгэдэл зүйн тогтолцоо, түүний чанарыг тайлан унших нь. Study on Mongolian Symbolism: Quest and Perspectives. Олон улсын эрдэм шинжилгээний хурал. УБ. 2009
33. Дьяконова В.П, Некоторые этнокультурные параллели в шаманстве тюркоязычных народов Саяно-Алтай. Л. Наука, 1984
34. Екатерина Дэвлет, Чжан Со Хо. Каменная летопись Алтая . М. 2014
35. Иванов С.И Материалы по изобразительному искусству народов Сибири. Ленинград. 1963
36. Катуу Б, Дөрвөд аман зохиолын чуулган, Улаанбаатар 2017
37. Лувсанбалдан Х, БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг, II дэвтэр, Ойрад аялгуу, а-w, Улаанбаатар 1988
38. Лхагва О, Мөнх тэнгэр суу заль орчлон. УБ. 2013
39. Лхам Д, Мянгад ардын зан үйл аман зохиол. Улаанбаатар, 1991
40. Майдар Д, Дарьсүрэн Л. Гэр /Хян. С.Бадамхатан. УБ, 1976
41. Монгол улсын их хурлын тогтоол. Дугаар 52.-Төрийн ордон. УБ. 2020

42. Монголын Алтай Соёны бүс нутгийн иргэдийн байгаль хамгаалах уламжлалт зан үйл сэдэвт судалгааны тайлан. ХИС-ийн Түүхийн тэнхим, гар бичмэлийн фонд, 12х
43. Монголын археологийн өв. Монгол улсын Шинжлэх ухааны Академи, Археологийн хүрээлэн. Чингис хаан музей. УБ. 2022
44. Мөнхбаяр Ч, Хуурай салаан амны I Чемурчек булшны зосон хээ хийгээд монгол гэрийн үүсэл хөгжлийн асуудалд. УБ. 2021. Монгол гэрийн соёл. ОУЭШХ-ийн эмхтгэл. 48-52х
45. Мэнэс Г, Монгол улсын угсаатны зүй 2 боть, Ойрадын угсаатны зүй. XIX-XX зууны зааг үе, 7 бүлэг Захчин, УБ. 2012
46. Мэнэс С, Захчин түүхэн угсаатны зүй. Улаанбаатар, 2019
47. Наваан Д, Дорнод Монголын хүрлийн үе. УБ. 1971
48. Намсрай Н, Өөлдийн соёл, түүхийн бичиг оршивой. Улаанбаатар, 2019, 28х.
49. Новгородова Э.А, Мир петроглифов Монголии. М. 1984
50. Нямбуу Х, Монгол хувцасны түүх. УБ. 2002
51. Окладников.А.П, Центрально-Азиатский очаг первобытного искусства. М. 1972
52. Плано Карпини, Вильгельм Рубрук Путешествие в Восточные страны Плано Карпини, Вильгельм Рубрука М. 1957
53. Пүрэв О, Монгол бөөгийн шашин. УБ. 1999
54. Пэрлээ Х, Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь. ШУАХ., Улаанбаатар, 1976
55. Шинэхүү М, Орхон-Енисейн бичиг монголын малын тамгатай холбогдох нь. <<Studia Ethnographica>>, Tomus V, Fasc. 8, Улаанбаатар, 1977
56. Баттулга Ц, Монголын руни бичгийн бага дурсгалууд. Тэргүүн дэвтэр, Corpus scriptorum, Tomus I, Улаанбаатар, 2005
57. Рубинштейн.С, Основы общей психологии. М. 1945
58. Роломжав Б, БНМАУ-ын тариалангийн хураангуй түүх. "studies historica" сэтгүүл., УБ, 1986
59. Сүхбаатар О, Монгол хэлний харь үгийн толь (нэмэн засварласан хоёрдугаар хэвлэл). Улаанбаатар, 1999
60. Төрбат Ц, Монгол ба бүс нутгийн буган хөшөөний соёл. I боть. УБ. 2021
61. Төрбат Ц, Монгол ба бүс нутгийн буган хөшөөний соёл. II боть. УБ. 2021
62. Төмөрбат Ж, Монгол хээ угалзын санд. УБ 2022
63. Торгууд аман билгийн жишээ. ХИС, НХУС, Хэл зохиолын тэнхим УБ 2020

64. Хавх Н, Социологи, Монголын нийгмийн гүн ухааны зарим чиглэлүүд, Улаанбаатар, 2005
65. Цэвэл Я, Монгол хэлний товч тайлбар толь., Улаанбаатар, 1966
66. Чойсамба Д, Малын им тамга түүний хууль цаазны ач холбогдол., Улаанбаатар, 1974
67. Ширэндэв Д, Өөлдийн малын им тамга бусдаас ялгагдах нь. Ойрад монголчуудын биет бус соёлын өв, ОУЭШ-ний V их хурлын эмхтгэл. УБ, 2017, 363-367х.
68. Энхдаваа Д, Хөх дарх УБ. 2016
69. Эрдэнэбаатар Д, Идэрхангай Т. нарын Балгасын тал дахь Гол мод-2-ын Хүннүгийн язгууртны булшны судалгаа. УБ. 2015
70. Эрдэнэ Ч, Их гурвалжин: үгшил ба оргил тайллууд. Улаанбаатар, 1997
71. Эрдэнэ Ч, Бид ялав, УБ 1997-2012

#### **АМАН МЭДЭЭ ӨГСӨН ХҮМҮҮС:**

1. Авгас овогтой Даваажавын Чулуунбаатар. Өөлд ястай, эрэгтэй, 61 настай, ардын тоглоом наадмын өв тээгч, Ховд аймгийн Жаргалант сумын Баатархайрхан багт оршин суугч нарнаас 2021 оны 4 сард авсан аман мэдээ.
2. Баатар бээлийн хошуу, Торгууд таван сум, Бээлийн Торгууд, Таринчийнхан удамт Аюушийн Шаравын Гансүх. Одоогийн Ховд аймгийн Булган сумын Бүрэн хайрхан багт суугаа, нохой жилтэй, эрэгтэй, өндөр настантай 2019 оны 11 сард Булган сумын төвд хийсэн тэмдэглэл.
3. Баатарын Бямбажав. нас 62, хулгана жилтэй, Дөрвөд далай хааны Яргай ястай, буруу матаастай хойн дэгэрээ тамгатай Дөргөн сумын төвд 2022 оны 3 сард авсан аман мэдээ.
4. Баатарын Цээмаа Дөрвөд далай хаан, Яргай ястай, буруу матаастай хойн дэгэрээ тамгатай, 70 настай, могой жилтэй, Баатрын Бямбажав. Дөрвөд далай хаан, Яргай ястай, буруу матаастай хойн дэгэрээ тамгатай, 62 настай, хулгана жилтэй, настангуудаас Дөргөн сумын төвд 2022 оны 3 сарын 18 нд авсан аман мэдээ.
5. Даваадоржийн Эрдэнэчимэг, могой жилтэй, Ховд аймгийн Жагалант сумын Цамбагарав багт оршин суугч, 2020 онд “Наран-саран”, “Нас-буян” хэмээх “Ерөөлтэй залаа”-г зүү ороох оёдлоор оёж, малгайн хамт урлан, мартагдсан өвийг сэргээсэн байна.

6. Дашнямын Мөнхдалай Ховд аймгийн Булган сумын Бүрэн хайрхан багийн иргэн, Бээлийн торгууд, Бадаанхан элкэн, тахиай жилтэй, эрэгтэй, 53 настай, Булган сумын соёлын төвийн дарга
7. Дөрвөд далай хааны Эрдэнэ гүний хошууны Цагаагчууд овгийн Хасайн Намсрай, 64 настай, эрэгтэй, Увс аймгийн Зүүн говь сумын Өгөөмөр (2-р) багийн төвд суудаг настнаас 2020 онд амаар авсан мэдээ.
8. Лхагвын Цэнджаргал, 67 настай, эмэгтэй, мичин жилтэй, Дөрвөд далай хааны Яргай ястай, галтай хойн дэгэрээ тамгатай. Дөргөн сумын төвд 2022 оны 3 сард авсан аман мэдээ.
9. Дөрвөдийн амгаланг үүсгэгч Майдарийн гэгээний хийдийг үүсгэн байгуулагч, Дөрвөд далай хааны, цэцэгээс тодорсон Цэц вангийн хошууны, аав ноён Яргай ястай, Лэгзэнгийн Мигжин гуайгаас Дөргөн сумын төвд 2022 оны 3 сард авсан аман мэдээ.
10. Дөрвөд далай хааны, цэцэгээс тодорсон Цэц вангийн хошууны, аав ноён Яргай ястай, Дөргөн сумын номын санч Мигжингийн Биндэрьяагаас сумын төвд 2022 оны 3 сард авсан аман мэдээ.
11. Жанчивын Төмөрбаатар. Ховд аймгийн Алтай сумын Алтан гадас баг. 1948 онд төрсөн, эрэгтэй, Захчин, Эмчийнхэн элкэн.
12. Лхагвын Цэнджаргал, 67 настай, эмэгтэй, мичин жилтэй, Дөрвөд далай хааны Яргай ястай, галтай хойн дэгэрээ тамгатай. Дөргөн сумын төвд 2022 оны 3 сард авсан аман мэдээ.
13. Увс аймгийн Малчин сумын Баянхайрхан багын малчин, баяд, салдан долоо ястай, 69 настай, хоёр аагт олом тамгатай Ожилдойн Янжив
14. Мянгад сумын Цацаргант багийн иргэн, Халхын Ганбат, могой жилтэй, 58 настай, эрэгтэй, урдаа галтай сараалжин тамгатай, Мянгад уртын дууны өв тээгчээс Ховд аймгийн төвд “Цайны зам” өв соёлын наадам дээр 2022 оны 9 сарын 26 нд авсан аман мэдээ.
15. Одоогийн Мөнххайрхан сумын Алаг багийн иргэн, Баруун амбаны, Оорцог сумын, Хорхон элкэнээ, Салбин аравнаа, сэнжтэй нуман тамгатай, морин жилтэй, 69 настай Бадгарын Эрхэмбаяртай Ховд аймгийн төвд 2022 оны 4 сард авсан аман мэдээ
16. Олхонуд овогт заарин Д.Бямбадоржоос 1999 оны VIII сарын 20-нд тэмдэглэн авав. Заарин Д.Бямбадорж өөрийн нагац заарин Ванчин Найнаа буюу Чинчомбуугийн Ванчиндорж гуайгаас 1971-1972 оны үед залган авчээ.

17. Салзадын Бадам, нохой жилтэй, 89 настай, эмэгтэй, Бээлийн торгууд, Уянга омог, нартай саран тамгатай, Булган сумын Байтаг багт оршин суудаг настнаас 2022 оны 8 сард авсан аман мэдээ.
18. Саруул гүний хошуу, Мянгад сум, Шар хуурчид элкэнээ, сэнжтэй нуман тамгатай Хорлоон Баярсайхан, үхэр жилтэй, нас 62, Ховд аймгийн Дуут сумын төвд 2021 оны 3 сард авсан аман мэдээ.
19. Төслийн хүрээнд хээрийн судалгаагаар 2020 онд Ховд аймгийн Зэрэг сумын Бургасан багийн иргэн Дүгэржавын Амараагийн найран дээр хийсэн тэмдэглэл.
20. Түнжингийн Намсрай. 1939 онд төрсөн. Туулай жилтэй 83 настай, эрэгтэй. Дархан Бээсийн хошуу, Оорцог сум, Хорхон элкен, Сальбин арваны. Одоогийн Ховд аймгийн Жаргалант сум, Цамбагарав багт оршин суугч, өндөр настангаас 2020 онд Ховд аймгийн төвд авсан аман мэдээ.
21. Урианхайн баруун амбаны Оорцог сумын Хорхон элкэнээ Дэчингийн Отгонбаяр, Мөнххайрхан сумын Сэнхэр багийн иргэн, сэнжтэй нуман тамгатай, туулай жилтэй, 74 настай, эмэгтэй настнаас Баян-өлгий аймаг, Толбо нуур, “Өвөг урианхай” өв соёлын наадам дээр 2022 оны 7 сард авсан аман мэдээ.
22. Урианхайн баруун амбаны, Чойрд элкэнээ, шулдан нуман тамгатай, могой жилтэй, 70 настай, Баяан Батжаваас Мөнххайрхан сумын Алаг багт 2022 оны 10 сард авсан аман мэдээ.
23. 2022 оны 4 сард Дөрвөд далай хааны Дөрвөд ястай, Яргай овогтой, 70 настай, могой жилтэй, буруу матаастай хойн дэгэрээ тамгатай, Баатарын Цээмаа, мөн 62 настай, хулгана жилтэй, Яргай ястай, буруу матаастай хойн дэгэрээ тамгатай Баатарын Бямбажаваас Дөргөн сумын соёлын төвд авсан аман мэдээ.
24. Урианхайн зүүн амбаны хошууны сангийн сумын цагаантуг элкэнээ Шагдар овогт Даянбаа, эрэгтэй, 71 настай, одоогийн Баян-Өлгий аймгийн Буянт сумын дөрөвдүгээр багт суудаг настанаас 2019 онд амаар авсан мэдээ.
25. Урианхайн Хойд амбаны, Мянгад элкэний, Шар хуурчид овогтой Цэвэгийн Төмөрчулуун, тахиа жилтэй, нас 53, сумтай, дотор сэнжтэй нуман тамгатай, үе дамжсан дархан хүн. Ховд аймгийн Жаргалант сумын Бугат багт оршин суудаг. Ховд аймгийн төвд 2022 оны 3 сарын 22 нд авсан аман мэдээ.
26. Ховд аймгийн Мянгад сумын Мөрөн багийн иргэн, Басгад ясны Цагаан шувуут овгийн Гомбодоржийн Дуламсүрэн, 70 настай, дан сараалжин тамгатай, эрэгтэй настнаас Ховд аймгийн төвд “Цайны зам” өв соёлын наадам дээр 2022 оны 9 сарын 27 нд авсан аман мэдээ.

27. Ховд аймгийн Алтай сумын Тахилт багийн иргэн Дүрвээн Мөнхцэцэг, бар жилтэй, эмээ ээж Шоовойлоон Булганы хэрэглэж байсан захчин эмэгтэй цэгдэг, үсний гэр, токиг зэрэгт тулгуурлан, захчин эмэгтэй дээл, тоорцог, тоохуу оёж, иж бүрэн болгон 2022 оны 7 сард болсон “Тонжоо” өв соёлын наадамд оролцсон байна.
28. Ховд аймаг Жаргалант сум, Алаг толгой баг, Тооройгийнхан элкэнээ Санжаан Батмөнх, ёнгорон тамгатай, хулгана жилтэй, эрэгтэй, Захчин уртын дууны өв тээгчээс 2022 оны 10 сарын 14 нд авсан аман мэдээ.
29. Ховд аймгийн Алтай сумын Бодонч багийн иргэн Баатарын Дулмаа, 88 настай, хулгана жилтэй, зөв дэгэрээ тамгатай, эмэгтэй настнаас Алтай сумын төвд 2022 оны авсан аман мэдээ.
30. Хулан цувдаг ястай, 58 настай Надмидын Намсрайн аман мэдээгээр. Доорх гал тамгадын тухай 1983 оны 8-р сарын сүүлээр Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын иргэн, шавьдий ястай, шулдан гал тамгатай, 85 настай Лхамжавын Качи, тольтон бургууд ястай, шулдан гал тамгатай, 72 настай Бэгзийн Үрэл мөн ястай, мөн тамгатай, 69 настай Чимэдийн Жамбаа, тоос ястай, шулдан гал тамгатай, 52 настай Төрбатын Сандуй, илжигэд ястай, сартай гал тамгатай, 74 настай Арвагийн Содномчой, хар бургууд ястай, шулдан гал тамгатай, 57 настай, Магнайн Гэлэгбалсан, байлгас ястай, сэнжтэй гал тамгатай, 60 настай Батсуурийн Сандуй нараас тэмдэглэн авав.
31. Цэдэнбалжирын Нордууд. нас 73, эрэгтэй, бар жилтэй, ургийн овог боржигон, халх гаралтай ээж Дөрвөд, Дөрвөд далай хааны зөв матаастай хонин дэгэрээ тамгатай. Дөргөн сумын төвд 2022 оны 3 сард авсан аман мэдээ.
32. Чандмань уулын аймаг, Ханбаатар хайрханы хошуу, одоогийн Ховд аймгийн Зэрэг сумын Гүвээ багийн Авгас элкэний эмэгтэй, өндөр настан Мөнхөөн Шуурай, 86 настай, Ховд аймгийн төвд 2019 онд гараар тэмдэглэсэн тэмдэглэл. [Мөнхөөн Шуурай]
33. Чандмань уулын аймаг Ханбаатар хайрхан уулын хошуу Тавьнайхан элкэнээ Бөхчулууны Намсрайгаас одоогийн Ховд аймгийн Манхан сумын Төгрөг багийн Баянтүмбэ тавьтын харьяат, эрэгтэй, 96 настай, 2019 онд Манхан сумын төв дээр тэмдэглэсэн яриа.
34. Чандмань уулын аймаг Ханбаатар хайрханы хошуу одоогийн Ховд аймгийн Зэрэг сумын Гүвээ багийн Яргайтын Хадаан ёроолд 1947 онд төрсөн, Авгас элкэний 72 настай, эмэгтэй Мөнхөөн Бааст гэх настны яриаг 2022 онд Зэрэг сумын төвд гараар тэмдэглэсэн тэмдэглэлээс.

35. 2022 оны 4 сард Дөрвөд далай хааны Дөрвөд ястай, Яргай овогтой, 70 настай, могой жилтэй, буруу матаастай хойн дэгэрээ тамгатай, Баатарын Цээмаа, мөн 62 настай, хулгана жилтэй, Яргай ястай, буруу матаастай хойн дэгэрээ тамгатай Баатарын Бямбажаваас Дөргөн сумын төвд авсан аман мэдээ.
36. Чандмань уулын аймаг Ханбаатар хайрхан уулын хошуу, Тооройгийнхан элкэнээ Санжаан Батмөнх, ёнгорон тамгатай, хулгана жилтэй, 62 настай, Ховд аймгийн төвд авсан аман мэдээ
37. Чойжингийн Намхайням, морь жилтэй, 56 настай, эрэгтэй, Бээлийн торгууд, Хөнхөр омог, нартай саран тамгатай, Булган сумын Байтаг багийн иргэн, 2022 оны 8 сард авсан аман мэдээ.
38. 2004 оны 8-р сарын 8нд Увс аймгийн Малчин сумын 2-р багын харьяат, 64 настай, баядын их цагаан тайж ястай, хоёр аагтай олом тамгатай Цэрэнгийн Дамдинсүрэнгээс “Малчин” сумын төвд тэмдэглэж авав.
39. 2004 оны 8-р сарын 24-нд баядын бүрдүүд ястай, жинстэй олом тамгатай, 82 настай өтгөс Ожилдайн Намсрай гуайгаас (хуучин Эрдэнэ гүнгийн хошуу) Улаангом хотод тэмдэглэж авав.
40. 2004 оны 8-р сарын 24 нд баядын шарнууд ястай, жинстэй олом тамгатай, 75 настай, Чүүчаагийн Сундуй гуайгаас Улаангом хотод тэмдэглэн авав.
41. 2004 оны 8-р сарын 24-нд баядын шарнууд ястай, жинстэй олом тамгатай, 75 настай өтгөс Чүүчаагийн Сундуй гуайгаас Улаангом хотод тэмдэглэн авав. Худам монгол бичигтэй. Эцгийн бичиж үлдээсэн тэмдэглэлээс өөрийн удам угсааг мэдэж авчээ. Үүнд: 1. Хүлэг 2. Хүлтэг 3. Андгал 4. Сэлэнгэ 5. Шувуун 6. Чүүчаа 7. Цээпил 8. Сундуй нар болно.
42. 2020 оны 5 сард Ховд аймгийн төвд Авгас ястай, шулдан гал тамгатай, хулгана жилтэй Даваажавын Чулуунбаатарын аман мэдээ
43. 2021 оны 5 сард Дархан бээсийн хошуу, Сэрвээ сумын Шажин элкэнээ, шулдан нуман тамгатай Шилэгийн Цэцэгмаа, хулгана жилтэй, 75 настай, эмэгтэй настнаас Ховд аймгийн төвд авсан аман мэдээ
44. 2021 оны 3 сарын 12 нд Зэрэг сумын өндөр настан, нохой жилтэй, бүргэд овогт Доржийн Дүгэржав, эрэгтэй, нас 77, (буруу эрчтэй) эм, босоо, том дэгэрээ тамгатай, Зэрэг сумын төвд авсан аман мэдээгээр
45. 2022 оны 3 сард Зэрэг сумын өндөр настан, морь жилтэй, бүргэд овогт Доржийн Мягмар, эрэгтэй, нас 72, (буруу эрчтэй) эм, босоо, том дэгэрээ тамгатай, Зэрэг сумын төвд авсан аман мэдээгээр




46. 2022 оны 5 сард Засагт хааны Дайчин гүний хошуу, Мянгад ястай, Ханд овогтой, хонин жилтэй, хойшоо харсан галтай жижиг сараалжин тамгатай, 80 настай, эрэгтэй, одоогийн Мянгад сумын, Баянбулаг багийн иргэн Дарьжавын Түвшингээс Мянгад сумын төвд авсан аман мэдээ.
47. 2022 оны 6 сард Бээлийн торгууд, Хүндийнхэн омог, дан саран тамгатай, нохой жилтэй, 89 настай, эрэгтэй Сүрэнгийн Хульдаагаас Булган суманд авсан аман мэдээ
48. 2022 оны 6 сард Дархан бэйлийн хошуу, Оорцог сумын, Хорхон элкэн, Салбин арваны шулдан нуман тамгатай, Түнжингийн Намсрай, туулай жилтэй, 85 настай, эрэгтэй настнаас Ховд аймгийн төвд авсан аман мэдээ.
49. 2022 оны 6 сард авсан аман мэдээ. Урианхайн Хойд амбаны, Мянгад элкэний, Шар хуурчид овогтой Цэвэгийн Төмөрчулуун, тахиа жилтэй, нас 53, сумтай, дотор сэнжтэй нуман тамгатай, үе дамжсан дархан хүн. Ховд аймгийн Жаргалант сумын Бугат багт оршин суудаг.
50. 2022 оны 6 сард Бээлийн торгууд, Хүндийнхэн омог, дан саран тамгатай, нохой жилтэй, 89 настай, эрэгтэй Сүрэнгийн Хульдаагаас Булган суманд авсан аман мэдээ.
51. 2022 оны 6 сард Бээлийн торгууд, Хүндийнхэн омог, дан саран тамгатай, нохой жилтэй, 89 настай, эрэгтэй Сүрэнгийн Хульдаагаас Булган суманд авсан аман мэдээ. [Сүрэнгийн Хульдаа]
52. 2022 оны 7 сарын 01 нд, Мөст сумын Баянхайрхан багийн Ут салаад авсан аман мэдээ. Захчин хошууны Аатийнхан элкэний Баярын Нарандулам, зөв, босоо дэгэрээ тамгатай, морин жилтэй, эмэгтэй, 56 настай.
53. 2022 оны 7 сарын 01 нд, Мөст сумын Баянхайрхан багийн Ут салаад авсан аман мэдээ. Захчин хошууны Шарынхан элкэнээ, Замилангийн Хүрэлбаатар, зөв, уужим, босоо дэгэрээ тамгатай, хулгана жилтэй, эрэгтэй 62 настай.
54. 2022 оны 7 сард Ховд аймгийн Үенч сумын төвд, Захчин гүнгийн хошууны хар хүүхэнээхэн элкэнээ, гахай жилтэй, зөв эрчтэй босгон дэгэрээ тамгатай, эрэгтэй, Болион Сундуйгаас авсан аман мэдээ.
55. 2022 оны 7 сард, Тавтад, захчин түмний Тонжоо наадам дээр, Үенч сумын, Цагаан түнгэ багийн иргэн, гүнгийн хошууны Адуучынхан овогтой, босоо, зөв, уужим дэгэрээ тамгатай, эрэгтэй, тахиа жилтэй, Сээхаарийн Бадрахаас авсан аман мэдээ.

- 56.2022 оны 7 сард Ховд аймгийн Үенч сумын төвд, Захчин гүнгийн хошууны Вангаанхан элкэнээ, нохой жилтэй, босоо, зөв дэгэрээ тамгатай, эмэгтэй, Лаажан Даваажавас авсан аман мэдээ.
- 57.2022 оны 8 сард Мөнххайрхан сумын Борт багт, Урианхайн баруун амбанаа Хорхон элкэнээ Ишээн Олзвой, могой жилтэй 82 настай, сэнжтэй нуман тамгатай, эрэгтэй настнаас авсан аман мэдээ.
- 58.2022 оны 8 сард Бээлийн торгууд, Хүндийнхэн омог, дан саран тамгатай, нохой жилтэй, 89 настай, эрэгтэй Сүрэнгийн Хульдаагаас Булган суманд авсан аман мэдээ.
- 59.2022 оны 10 сард Засагт хааны Дайчин гүний хошуу, Мянгад ястай, Газарч овогтой, тахиа жилтэй, урдаа галтай давхар алхан тамгатай, 66 настай, эрэгтэй, одоогийн Мянгад сумын, Чацарганат багийн иргэн, аймгийн алдарт уяач Бямбажавын Ганбатаас Мянгад сумын төвд авсан аман мэдээ.
- 60.Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын Баянбулаг багийн иргэн, Зүүн амбаны Мээрэнгийн хошууны Урианхан элкэнээ Мэнэрэлийн Бумцэнд, луу жилтэй, 70 настай, хөвчтэй нуман тамгатай настнаас 2022 оны 7 сарын 28 нд Баян-Өлгий аймгийн төвд авсан аман мэдээ
- 61.2022 оны 7 сард Баян-Өлгий аймгийн Толбо сумын Толбо нууранд болсон өвсоёлын наадмаар, Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын Баянбулаг багийн иргэн, Зүүн амбаны Мээрэнгийн хошууны Их дууныхан элкэнээ Савдангийн Даваажав, бар жилтэй, 60 настай, шулдан нуман тамгатай настнаас авсан аман мэдээ.




ХАВСРАЛТ:

Тамга, хээ угалзын дүрс































# Захчин























Торгууд













Дөрвөд, Баяд























Ховд сум



Наранбулаг сум



Дөргөн сум























Өөлд


















Урианхай





















# Баруун Халх





